

Ундрам төвийн хамгаалагч Дэд хурандаа Дугаржавтай хийсэн ярилцлага

Ярилцлага авсан төслийн удирдагч Ирина Морозова болон /цаашид И.М гэх/, докторант М.Энхбаатар /цаашид Э гэх/ нар.

/Улаанбаатар хот 2012 оны 8 сарын 11, Бямба гариг/

Өнөөдөр Дугаржав гэж хүнтэй уулзаад байна. Тэгээд та, Дугаржав гуай та өөрийгөө танилцуулаад, хэдэн онд хаана төрсөн, өдийг хүртэл хаана хаана ажиллаж байв? Ямар сургуульд сурав гээд өөрийгөө товч танилцуулаад яриагаа эхлэе дээ.

Д: За миний хувьд бол Зэвгээ овогтой Дугаржав гэдэг, 1954 онд энэ Улаанбаатар хотод төрсөн л дөө. Яахав аав ээжийн минь нутаг Булган аймаг, за миний хувьд яахав 10 жилийн сургууль төгсөөд цэргийн албанд яваад тэгээд цэргээсээ тэгээд ерөөсөө хилийн цэргээр явсаар байгаад одоо 34 жил хилийн цэрэгт алба хаагаад тэгээд 2006 онд тэтгэвэртээ гарсан цэргийн хүн байгаа юм. Тэгээд яахав цэргийн сургууль төгссөн, хилийн цэргийн дээд сургуулийг дотоодод монголдоо, ерөнхийдөө бол тэгээд улсын хилээр л тойрсон хилчин хүн дээ.

Э: Аанхаан, аль аль хилийн застав, отрядуудад ажиллаж алба хааж байв?

Д: За миний хувьд бол анх бол энэ 05-р анги гэж хотод хилийн цэргийн ангид цэрэгт ирснээсээ хойш Сулин хээрийн отряд гэж, дорноговь аймгийн сулин хээрийн отрядад, тэнд анх очиж цэргийн алба хаасан. Тэндээсээ эхлээд ерөөсөө миний амьдрал хилийн цэрэгтэй холбогдсон юм байгаа юм.

Э: 1972 онд очсон уу?

Д: Тийм, 1973 онд очсон, Сулин хээрт очоол, тэгээд тэндээсээ хилийн цэргээрээ дамжаал, тэгээд тэрнээсээ хойш миний амьдрал хилийн цэрэгтэй холбогдсон юм байгаа юм. Тэгээд тэндээсээ 1973 оноос хойш 220 гэж Дархан хотын хамгаалах салбарт ажиллаж байлаа, дараа нь сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хилийн отрядад 10 гаруй жил ажиллалаа, за мөн тэрний дараа сэлэнгийн хилийн шалган нэвтрүүлэх анги байдаг, тэнд бас нэг 3-4 жил ажиллалаа. Эргээд урагшаа Дорно-Говийн Замын-Үүдийн шалган нэвтрүүлэхэд бас нэг 5-6 жил ажиллалаа. Бас хойшооноо эргээд Хэнтийн Дадал сумын , бас оростой хиллэдэш, отрядад ажиллалаа. Тэгээд л улаанбаатар хотод орж ирээд одоо арваад жил амьдарч байна даа.

И.М: Аа таны ээж, аав Булган аймгийн ямар сум?

Д: Булган аймгийн Тэшиг сум гээд хойд талдаа байдаг, оростой хиллэдэг

Э: Болдбаатар багшийн нутаг байна

И.М: Аа, аа тийм байна.

Э: Манай төслийн, миний удирдагч багш болвол академич Болдбаатар гэж хүн байдаг. Тэр хүн бол Булган аймгийн хүн.

Д: Аан тийм. Булган аймгийн хүн ш дээ. Сайн мэднэ манай нутгийн хүн.

Э: Тэгээд сая манай энэ хүн /И.М/ Болдбаатар багштай хамт Булганы Могод яваад, Булганы хөдөөгийн хүмүүсээс ярилцлага аваад ирсэн. Тэгээд таныг Булган нэсэн болохоор аль сум юм бэ гэж асууж байна.

Д: Аан тэшиг сум, би чинь 10 жилийнхээ сургуулийг Булган аймагт төгссөн, манай өвөө, эмээ, ээж, аав булганы тэшигт байдаг байсан. Багадаа би чинь сургуулийн чөлөө завсраар амралтаараа очиж хонь мал хариулдаг, булганы тэшиг суманд бол тэгж байсан тийм юм байгаа юм тийн.

Э: Дарга аль заставт томилсон тэрүүгээр л явна даа тиймээ?

Д: Ер нь хилийн цэрэг бол бид нар чинь тэгээл тухайн үед аль заставт, аль отрядад ажиллахыг хилийн цэргээс тушаал гаргаал за тэр отрядын, тэр заставт тэгж ажиллана гээл томилолт аваал явдаг тийм үе байлаалдаа. Тэр үед бол ерөөсөө гэр бүлээ дагуулаал, хүүхдээ чирээд явна.

Э: Гэр бүл гэж, та хэдэн онд гэр бүлтэй болсон бэ?

Д: Би 1974 онд тэр Сулин хээрийн отрядад байхдаа заставын даргынхаа охинтой анх танилцаж байсан юм. Тэнээд би тэндээсээ сургуульд яваад, тэгэхэд хилийн цэргийн дунд сургууль гэж байсан тэрэндээ офицерын курс төгсөж очоод гэр бүлийнхээ хүнтэй, нэр ёсондоо 1974 онд гэр бүл болж, заставынхаа даргын охиныг авч, удам залгасан хилчний охиныг авч, өөрөө хилчин болоод ингээд явсан их сонин түүхтэй.

Э: Аан, ингээд гэр бүлтэй хилчин хүний хувьд тухайн социализмын үед ахуйн хангамж хэр вэ?

Д: Яах вэ, Хилийн цэргийн хувьд бол хилчний ахуйн хангасж их сайн байсан. Яагаад гэвэл урд хил дээр чинь бид улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулдаг, хятад бол тэр үед тагайхтай их хүндрэлтэй, хилийн зөрчил их гардаг, ийтэрхүү л байлаа ш дээ. Тэгээл ерөөсөө улсын хилийг бол урд хилийг л хамгаалах, энэ хамгаалалтанд оролцож байгаа бидний хувьд хилийн цэргийн хангалт бол маш сайн байсан. Ялангуяа хилийн застат ажиллаж байгаа энэ үед цаанаасаа хангалттай өгчихдөг, хангамж бол сайн байсан.

Э: Та бид нарын сонирхож байгаа өөрчлөн байгуулалт гэж хэлж байгаа 1982,1984 оноос хойших үед яг хаана байсан бэ?

Д: За би бол яг 1981 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэ-Цагааны отрядад ажиллаж байсан. За яг 1981 онд бол би хилийн заставын орлогчоор томилогдож очиж ажиллаад 1984 онд хилийн заставын дарга хийж байсан юм байгаан. Тэр үед бол яг Перестройка , Горбачёвын

өөрчлөн байгуулалт яригдаж байсан л даа. Ингээд л ЗХУ-ад өөрчлөн байгуулалт явагдах гэж байнаа гэх мэтчилэн янз бүрийн асуудал их л яригддаг байсан. Тэр үед заставт бол телевизор байгаагүй, зүгээр радиогоор сонсдог, мэдэрдэг тийм байлаа. Тэрнээсээ би залгуулаад 1989 он хүртэл цагааны отрядад бол ажилласан л даа, тэнээл 1989 он, 1990 оны үеэс эхлээд бас нэг тийм асуудал Монголд яригддаг байхгүй юу, ерөнхийдөө бол энэ өөрчлөн байгуулалтын үр нөлөө Монголд орж ирлээ гэдэг асуудал гараад, Улаанбаатар хотод чинь тэр үед жагсаал цуглаан хийдэг байлаа ш дээ. За яг тэр үед бол бид нар хилчин хил дээр байсан учраас ийм үймээн самуун, хилийн үймээн самуунаас гадна, дотоодод ийм үймээн самуун гарахнээ, ийм учраас энэ асуудлыг далимдуулаад гадаадаас хил зөрчих, хилийн янз бүрийн асуудал гарч болзошгүй учраас хил дээр урьдчилан хамгаалалт хийнэ гэж тушаал өгдөг байлаа. За тэгээл тэр үед нь бид хил дээр урьдчилан хамгаалалт хийгээл, дотоодод юу болж байгаа бол гээд бас их чагнадаг байсан л даа. Тэгтэл энэ улаанбаатарт чинь жагсаал цуглаан хийгээл, янз янзын асуудал гараад л , улс төрийн товчоог огцруулна барина гээд л янз янзын л асуудлууд гардаг байсан. Тэгээд тэр үед чинь бид чинь тийм юм сонсоогүй социализмаар хүмүүжчихсэн улс чинь юу болох бол, ямар юм болох бол гээд бас их чих тавиж, чагнадаг л байсан л даа.

Э: Цэргийн хүний хувьд тушаал биелүүлээд явна, гэхдээ цэрэг хэдий ч хүн, та заставын дарга учраас заставын хилчин байлдагч, офицеруудын сэтгэл санаа улс төрийн хувьд ямар байна, улаанбаатарт болж байгаа зүйлийг хэрхэн яаж үзэж, үнэлж байна, хэрхэн хандах нь уу гэдгийг ажиглаж л байсан байх?

Д: Тийм, Ер нь бол албан тушаал алдар цол гээд л байхад чинь, бид нарыг чинь хилийн заставын орлогч нар чинь бүгд МАХН-ын гишүүн бол элсүүлдэг байлаалдаа. Тэр үед чинь нам гэдэг чинь нэлээн нөлөөтэй ийм юу байлаашдээ. Тэгээд ерөөсөө ялангуяа хилийн заставын дарга орлогч нар чинь намын гишүүн байх ёстой. Нам гэдэг чинь их хүчтэй байсан үе шүүдээ. Тэгээд л тэр үед чинь энэ бүхний чинь эсрэг гэхиймуудаа өөрчлөн байгуулалт хийнэ тэгээд л улс төрийн товчоог огцруулна эд нар гээд л асуудал гараад ирэхлээр чинь бас л одоо энэ тал дээр чинь бас сонирхдог байсанлдаа. Ялангуяа офицеруудын хувьд бид нар хоорондоо ярьдаг л байсан. Энэ ер нь зөв үү буруу юу гэж гэхдээ энэнийг чинь энгээд бодоод үзэхлээр бид нарын чинь хувьд бас нэг сэхээтэн офицеруудын хувьд ер нь монголд өөрчлөн байгуулалт хийх нь зөв юм ер нь энэ хийгдэж байгаа монголд явагдаж байгаа асуудал ер нь их зөв зүйтэй асуудал гэдгийг бид нар хоорондоо ярьдаг байсан. Гэхдээ бид нар цэргийн хүний хувьд бол тэр хугацаат цэргийн албан хаагч нарыг ерөөсөө улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулах ёстой. Гадаадаас ямар нэгэн зөрчил гаргуулахгүй байх дотоодод асуудал болоход одоо хилээ хамгаалах ийм л үүрэгтэй гэдэг талаар бид нар анхааруулж хэлдэг л байсанлдаа.

Э: Зүгээр жирийн хилчин байлдагч нараас гадна одоо янз бүрийн улс төрийн сэдэвтэй асуулга тавих, яриа лекцийн үеэр асуулга тавих гэдгиймуу тийэрхүү зүйл байх уу?

Д: Ерөнхийдөө энэ улс төрийн асуудлыг бол манай улс төрийн орлогч л хариуцдаг байсанлдаа. Миний хувьд л бол ер нь заставын дарга гэдгийнхээ хувьд ерөнхийд нь зохион байгуулдаг. Аан ер нь улс төрийн орлогчдоо бол энэ талаар бол бид нар бас ярьдаг үүрэг өгдөг байсан. Аан хугацаат цэргийн албан хаагчдын хувьд маш зөв ойлголт өгөөрэй бас ямарваа нэгэн асуудалд туйлшрахгүйгээр асуудалд зөв ойлгуулж бас мэдээллийг зөв талаас нь өгөөрэй гэдэг байсан. Аан ерөнхийдөө бол энэ талаар бас цэргүүд бол ерөнхий ойлгоц бол авдаг л байсан. Бид нар бол энэ бүхнийг нуугаад байх шаардлага байхгүйлдээ. Ямар ч байсан хугацаат цэргийн албан хаагчдад үнэн зөв мэдээлэл өгч байж л бид нар чинь өгөх зүйлээ өгнө шүүдээ. Тийм учраас өөрчлөн байгуулалт гэдэг асуудлыг чинь бол бид нар ерөнхийдөө бид нар бол номноос уншдаг л байсан. Тэр Горбачевын өөрчлөн байгуулалт гээд л номон дээр гарцан байдаг тэрнээсээ бид нар нийгэм бол өөрчлөгдөх ёстой ер нь одоо эрх чөлөөтэй бас нэг чөлөөтэй сэтгэж бас чөлөөтэй зах зээлд орж чөлөөтэй амьдрах нь бол ёстоймоо гэдгийг хэлдэг хэлж ухуулдаг л байсанлдаа. Зөв ойлголт өгөхийн тулд энэ талаар бол ярьдаг л байсан.

Э: Та 91 оноос хойш хаана байв?

Д: За 91 онд би 91 онд юу яагаад хотд бишээ Сэлэнгийн байцаан өнгөрүүлэхэд ажиллаж байсан 91 онд отрядын төв орж аан би 91 оноос чинь отрядын төвд 95, 94 он хүртэл байсын байна. 93 оны замар сэлэнгийн отрядад шилжиж байсан. Тийн 93 он хүртэл.

Э: 93 он хүртэл Улс Төрийн Товчоо огцроод л жагсаал цуглаан болоод л өлсөглөн зарлаад л энгээд Улс төрийн товчоо огцроод төр бол шинэ хэлбэрээр зохион байгуулалтаа хийгээд энгээд өөрчлөлт хийгээд ирэх дээр зэрэг хөдөөгийн ард иргэдийн хувьд, таны хувьд, таны амьдрал гэр бүл гэр бүлийн амьдрал одоо тэр эдийн засгийн амьдрал нийгмийн өөрчлөлт хэрхэн яаж тусч байв тэрний нөлөө тэрний ер нь мэдэгдэж байсан зүйл?

Д: Ер нь тийм шүү 90 оноос тэр нөгөө өөрчлөнө тэ юу улс төрийн товчоо огцроно өлсөглөн зарлана гээд тэр талаар тээ тэгээд улс төрийн товчоо эд нар огцроод л энгээд л одоо асуудлууд явагдаж эхэлсэнлдээ тээ. Тэгээд энгээд эрэнгүүт чинь нөгөө бид нарын хувьд ерөөсөө тэгээд 1т намын харяалалгүй болсон бид нар чинь дандаа МАХН-ын гишүүд байлаашдээ. Тэгэхэд чинь тэгээд сүүлдээ хүчний байгууллагуудыг чинь намын харяалалгүй болгоно гээд бүгдийнэ бид нар чинь намын батлахаа хураалгаад энгээд ерөөсөө нам бус болж байгаа байхгүй юу. Энгээд нэгдүгээр өөрчлөлт нь энэ болсон. Ерөөсөө бүх юмыг намаар далаалгаж бүгдийг энгэдэг байсан бол бидний хувьд нэг бодлын нам гэдэг асуудлаас салж өөрсдийнхөө бүх үйл ажиллагааг өөрсдийнхөө сэтгэл санаагаар яаж зохион байгуулахав яаж хийхүү гэдэг нэгдүгээр өөрчлөлт болсон. Хоёрдугаарт тэр үед чинь бас нөгөө зах зээлийн харьцаанд анх шилжиж байна гээд тээ энгээд л эхэлсэн ер нь тэгээд л юм хөдөөний хувьд эдийн засгийн хувьд тэр юм бол маш их хомсдолд орсон одоо тэгээд хүнс хоолноос эхлээд бараа бүтээгдэхүүн маш нэг хэсэг маш их хомсдолд орж картын бараанд ороо биздээ тээ тэгэхэд би бол ерөөсөө эрдэнэцагаан суманд отрядын төвд хүнсний агуулахын даргаар томилогдож ирцэн

байсанлдаа. Энгээд ирэхэд нөгөө хүнс хоолны асуудлыг чинь би хариуцдаг байхгүй юу. За энгээд ирсэн чинь хүнс хоол бол маш их одоо хомсдолд орж эхэлсэн. Тухайн үед чинь ерөөсөө төвлөрсөн зах зээл юунаас чинь хангалтаа хийчихдэг бид нар чинь Улаанбаатар аймгаас ирээд л бүх гурил будаа цэргийн хүнсийг чинь машинаар ачаад л явчихдаг байлаашдээ. Тэгээд л цэргийн хүнс бол чөлөөтэй. Тэгээд энгээд ирсэн чинь зах зээлд ороод ирсэн чинь нөгөө төвлөрсөн хангалт байхгүй болоод энгээд ирэнгүүт ерөөсөө юм хомсдолд орж эхэлсэнлдээ. Цэргийн хүнс ч хомсдож эхэлсэн нөгөө офицер ахлагч нарын хангалт ч хомсдож эхэлсэн ерөөсөө махнаас өөр юм байхгүй. Бид нар бол мал ихтэй байсанлдаа малтай байсны хүчинд ямарч гэсэн малынхаа махаар л тусалдаг байлаа. Тэгээд нөгөө гурил будаа чинь хомсдоод эхлэхээр зах зээлд чинь ерөөсөө тэр үед чинь сумын дэлгүүрт лангуун дээр ерөөсөө давснаас өөр юм байхгүй байсаншдээ. Ерөөсөө л давс л байдаг байсан. За тэгээд гурил будаа хомсдоод энгээд бас ард түмний амьдрал хүндрэлд орж байсан үе нэг үе нэг хэсэг үе бол байсан. За тэгээд бид нар чинь энэнийг давж гарахын тулд зэргэлдээ Сүхбаатар аймаг, Дорнод аймаг гээд аймгуудруу яваад аймгуудын хүнсний комбинатай уулзаад гэрээ эд нар хийгээд энгээд хүнс хоолоор хангах гээд тэгээд мөнгө төгрөгний асуудал бас хүнд болж ирсэн төсвөөс бэлэн юм ороод ирдэг байсан бол одоо энгээд зах зээлийн үнээр худалдаж авдаг тэрнийг чинь нааш цааш нь татах гээд нэлээн маш их хүндрэлтэй за тэгээд дээр нь бензиний асуудал бас хүндрэлтэй болж ирсэн гэх мэтчилэнгээр ерөөсөө яг тэр үедээ бол 91, 92 оны үед 93 он хүртэл бас нэлээн хүндрэлийг бол бид нар давсан шүү.

Э: 90-ээд он гараад өмч хувьчлал, Засгийн газрын 20-р тогтоол гээд огцом огцом өөрчлөлтүүд гараад тэгээд цэргийн хүний хувьд хөдөө байсан тэдний хувьд тэр өмч хувьчлал гэж ер нь танд хэр ойлголт бууж байв ер нь тэр өмч хувьчлалд оролцох өөрийн гэсэн хувьдаа өмчтэй болох түүгээрээ ашиг олох ч гэдэг юмуу тийм боломж одоо ойлголтууд хэр байвдаа?

Д: За тэгээд өмч хувьчлалын асуудлууд яригдаж эхэлсэнлдээ. Тэгэхэд бол тэгээд хөдөөгийн малчдад малыг нь энгээд өгөх юм гэнээ одоо тэгээд хариулж байгаа мал нь одоо тэр хүний малчин хүнийх болох юм гэнээ тиймээ тэгээд л өмч хувьчлалын анхны л юмнууд яригдаж байсанлдаа. Яахав зүгээр малчин нь тэгээд л малаа хувьдаа аваад энгээд л болцгоосон за цэргийн хүний хувьд ч одоо юу байхавдээ өмч гэж юм байсангүй ерөөсөө цэргийн хүн гэдэг бол нөгөө утга агуулгаараа бид нарыг чинь социализмын үеэс өмчтэй байж болохгүй гээд ерөөсөө сургачихсан. Тэр үед би бас нэг инээдтэй юм гэхээр би бас хилийн заставын дарга байхдаа нутгийн малчидтай бас нэг наана цаана уулздаг байхгүй юу тэгэхэд надад нэг нутгийн малчин хоёр айл нь нэг хоёр охин бяруу өгсөн юм. За тэгээд тэр хоёр охин бяруугаа айл дээр тавьчихаад тэгээд энгээд одоо ухаандаа хувийн өмчтэй л болох гэж байгаагийн эхлэл л тэр юм байналдаа. Тэгээд л энгээд айл дээр тавьчихсан байсан чинь тэр одоо бид нарыг чинь одоо энгэдэг байлаашдээ үүрийн гишүүдийн хурал хийнэ хурал хийхэд чинь намын гишүүдээ комунистуудаа та нар хувийн өмчтэй байж болохгүй шүү хувийн өмчтэй та нар байхын бол ерөөсөө болохгүй шүү гэж бид нарыг

чинь энгэдэг байлаашдээ. Тэгэхээр бид нар чинь хувийн өмч гэх юм үндсэндээ байсангүй. Тэгээд харин 90 оны үед харин хоёр бяруу айл дээр байсан тэрнийгээ застав дээр авчирч тавьчихаад тэгээд ухаандаа хоёр үнээтэй болж байналдаа тэгэж нэг анх удаа хувьчлал гэх юмуу тийм юмтай болоод тэгээд нөгөө отрядын төвлүү шилжихдээ тэрнийгээ отрядын төв дээр авчраад аан отрядын төврүү шилжихдээ заставынхаа мал дээр орхиод явчихгүй юу тэгээд 92, 93 оны 93 оны үед би чинь наашаагаа шилжих юм болоод тэгээд тэр үед чинь анх хил гааль нээгдэж манай Эрдэнэцагаанд чинь бичигтийн боомт гэж анх нээгдээд тэгээд анх хятад монгол хоёрын хооронд анхны нөгөө боомт нээгдээд тэгээд нэг ордог гардаг тэнд чинь бас нөгөө Сүхбаатар аймгийхан чинь үзэмчингүүд их байдаг байсан байхгүй юу. Үзэмчингүүд чинь яг тэр нөгөө хоёр талд гарчихсан ах дүү нар нь хоёр талд гарцан бас ийм байсан. Бас тэгээд ах дүү нараа эргэж ирж уулзаад энгэж эхлэж байсан энгээд л одоо анх удаа хятадруу гарч Улиастай гэдэг хотд анх очиж наймаа арилжаа хийх юм чинь анх 92 оноос эхлэж анх хилийнхэн хийж байлаашдээ.

Э: Тэрэнд та хэр идэвхитэй оролцож байв?

Д: 91 оны сүүлээр бид нар чинь бас явсоон. 91 оны сүүлээр гэхээр чинь анх төмөр урагшаа гарсан байхгүй юу. Тэр үед чинь бол манай отряд анх зах зээлд шилжиж байхад манай орядын дарга тэр үед бас их зах зээлийн сэтгэлгээтэй хурандаа Чулуун гэж хүн байсан юм. Тэр бол ерөөсөө зах зээлийн асуудлыг мэдрээд төмөр байнашдээ хаягдал төмрүүд хаягдал төрүүдийг цуглуулаад тэгээд манай хилчин хилийн юунаас хилчин гэсэн юу аж нэгж гэхиймуудаа юу компани байгуулаад тэгээд одоо хятадруу хятадруу төмөр маш их хэмжээгээр гаргаж байсан. Тэгээд л одоо анх урдаас гурил, будаа, сахар тэгээд ойр зуурын юм үндсэндээ жижиг сажиг бараа анх авчирч ажилчиддаа өгч тарааж.

Э: Тэр гаргах төмөр нь ямар төмөр гаргаж байсан юм?

Д: Үгүйээ ерөөсөө хээр гадаа хэвтэж байгаа хар төмрүүд байнашдээ янз бүрийн машины сэлбэг төмөр янз бүрийн тэгээд бүр сүүлдээ зөвлөлтийн цэргийн яаж байсан янз бүрийн юмнуудыг тэрүүгээр ургаш нь гаргаж байсанлдаа. Тэгээд л зах зээлд шилжиж байгаа нь тэр. Тэгээд бас офицер ахлагч нартаа зохих хэмжээний хямдралтай үнээр хоол хүнсний юмыг зардаг тийм одоо байсан.

Э: Цэргүүдийн хувьд нэг өөрчлөлт гарсан нь жаран хэдэн оноос байсан нөгөө орос цэргүүд явлаа. Тэр ер нь цэргүүдэд улам илүү л өшөө л нөлөөлсөн болвуу гэж би боддог юм тэр орос цэргүүд социализмын үед орос цэргүүд орос цэргийн анги байх явсны дараах үе ч гэдэг юмуу тэр талаар?

Д: Тийн тэр үед Дорнод аймагт одоо маш олон юу орос цэргийн анги байсанлдаа. Бид нар бол яахав зүгээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаанд байсан ч гэсэн дорнодруу бол байнга явж дорнодоос хүнс хоол янз янзын юм авдаг байсан болохоор одоо Дорнодод байдаг орос цэргийн ангиуд гарсныг мэдэх юм. Тэгэхэд анх удаа ерөөсөө тэгээд л оросын цэргүүдийг гаргана гэдэг ийм асуудал яригдаж байсан за тэгээд нэг л өдөр гарсанлдаа. За тэгээд

тэгэхэд бол ерөөсөө манай тэр офицер ахлагч нар бол юу яадгийн яг тэр дорнодын хилийн цэргийн ангийн улсууд бол ярьдаг байхгүй юу ерөөсөө тэгээд нэг л өдөр түгшүүрийн дохио аваад орос цэргүүдийг бол гаргасан тэгээд байр сууц бүх юм л энгээд үлдсэн гэж ерөөсөө би ч гэсэн сүүлд нь тэгээд юулуу очиж байхад ерөөсөө тэгээд хуучин оросын цэргийн гаргасан байшин саваар орж үзэж байлаа тэгэхэд одоо нөгөө нэг юу бийшдээ пийшингүүд юу гэдэг билээ?

Э: Тоосгон пийшингүүд

Д: Үгүйгүй оросын нөгөө цахилгаан пийшингүүд тэр нь тэр дотроо үлдсэн тийм байж байдаг нутгийн ардууд бол тэр одоо орон сууцандаа үлдээсэн тэр юмнуудыг нь маш их түүсэн диван миван гээд хувцас хунар гээд бүх юмаа үлдээгээд гарсан юм байналээлдээ тэгээд сүүлд нь тэгээд л тэндээс чинь нөгөө цэргийн ангийн зэвсэг техник тэр бүх юмнуудыг чинь зармыг нь монголын талд шилжүүлсэншдээ тэгээл одоо хувцас хунар янз янзын тийм юмнууд бол манай анги манги бол авч л байсан тухайн үедээ бол оросын юунуудаас

Э: Аан та тэр нөгөө Сулинхээрийн Эрдэнэцагааны заставт отрядад байхдаа хотд ирж байсан уу? Орж ирж л байсан байх тэгээд ерөнхийдөө тэр өөрчлөлтөөс өмнөх хотд ирж байх дараа ирж байх хоёрын хоорондын ялгаа ямар санагдаж байсан бэ?

Д: Тийн ер нь бол яахав зүгээр манайхан бол социализмын үед хангалуун сайхан байсым бүх юм бэлэн гэж л ярьдаглдаа энэ бол яахав зүгээр цаанаасаа бүх юмаа хангадаг одоо тийм л юм байлаа шүүдээ гэхдээ тэнд бол хүний одоо нөгөө өөрсдийнхөө хэвлэн нийтлэх эрх чөлөө дутуу байлаа үг хэлэх эрх чөлөөнүүд байхгүй байлаа нэг санаан зоргоороо ярьдаг хэлдэг тийм юм бол маш хаагдмал байлаа шүүдээ. Тэгээд тэр үед чинь бид нар тэгээл амралтаараа хотруу орж ирэхэд бол ерөөсөө тэгээд л хүн болгоны ярьж байгаа юм ерөөсөө тэгээд одоо ухаандаа эрх чөлөө тиймээ ухаандаа зах зээлд шилжсэн ер нь бүх талын эрх чөлөөтэй болж авлаа иргэн хүний хувьд эрх чөлөөгөө эдлэх ёстой, өмчтэй болох ёстой, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй үг хэлэх эрх чөлөөтэй, жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй байх ёстой гэсэн ийм юмнууд бол яригдаж байсан аан социализмын үед бол энэ бүхэн маш их хаагдмал байсан. Аан тэгээд тэгэхэд бол ерөнхийдөө энэ бүх юмнууд чинь хотд бол бүх юм чөлөөтэй гэх юмуу тэгээд хүн болгон ерөөсөө энэ өөрчлөн байгуулалт зах зээл гэдэг юм ярьсан үе байсанлдаа.

Э: Та хэдийгээр цэргийн алба хааж байсан ч гэсэн нам бус болцон юм чинь бас нэг өөр намын гишүүн болоод улс төрийн амьдралд идэвхитэй оролцъя гэсэн санаа ч гэдэг юмуу тийм юм байвуу?

Д: За яах вэ ер нь тэр үед цэргийн улсууд хүчний байгууллагын албан хаагч нарыг тийм юманд оролцохыг хоргилдог байсан. За ямарваа нэгэн намд элсэх ямарваа нэгэн одоо улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй, дэмжихгүй ерөөсөө л өөрсдийн ерөөсөө албан үүргээ гүйцэтгэх ёстой гэдэг ийм байдлаар л одоо хангадаг байсанлдаа. Тийм учраас ер нь

цэргийн алба хааж байх үедээ бол тийм ямар нэгэн улс төрийн хүчнийг дэмжих намд элсэх тийм асуудал бол байгаагүй. Ерөөсөө л одоо үүргээ гүйцэтгэх тангараг өргөсөн цэргийн албан хаагчын хувьд бол одоо эх орны аюулгүй байдалд бэлэн байх гэсэн тийм л үүргээ гүйцэтгэж байсан.

Э: Өөрчлөн байгуулалтын үед яг тэр хүчлэн хамгаалалт эд нар авч байх үед таны түрүүчийн хэлсэн тэр асуудлууд буюу хятадын талаас ч юмуу дотоодоос үймээн самуун гарах гэдгийг таны хариуцаж байсан застав дээр тийм юм тохиолдох нь ер нь гайгүй юу?

Д: Ер нь бол гайгүй. Гэхдээ ер нь гадаад талаас бол ер нь ухаандаа дотоод талдаа тэгээд янз янзын жагсаал цуглаан хийгээд эхлэхээр чинь гадна талаас сонирхдог юм. Аан тэгээд зүгээр ганц нэг хил зөрчдөг хилийн янз янзын зөрчил бол гардаг л байсан. Бид нар тэгээд тэр бүхнийг зохих хэмжээгээр саатуулаад бариад тэгээд хүлээлгээд өгчихдөг л байсан. Тэрнээс биш нэг их тодорхой айхтар тийм аан өндөр тийм өдөөн хатгасан юмнууд бол тэр үед мэдэгдээгүйлдээ.

Э: Аан тэр зөрчлүүд нь ер нь ямар зорилготой улс төрийн зорилготой байдаг байсан юмуу өөр ямар зорилготой байдаг байсан юм бол?

Д: Яахав зүгээр тэр бол яахав зүгээр өнгөн дээрээ бол монголд амьдрья гэсэн одоо нэг тэнүүлчин байдлын л хүмүүс орж ирдэг л байсанлдаа. Тэгээл бид нар яахав тэрнийг чинь хил дээрээ саатуулна тэгээл ангийн юунд хүлээлгэж өгнө тэгээд тагнуулын байгууллага цааш нь шалгадаг л байсан байх яахав зүгээр яг тийм зорилготой ийм зорилготой гэдгийг бид нарт бол хэлж барьдаггүй байсан. Янз янзын зорилго байсан л байх.

Э: Ер нь худалдаа хийгээд явж байгаа хүмүүс хэр их хүмүүс одоо тэр 91, 92 онд Бичигтийн боомтоор хэр идэвхитэй бөгөөд хэр их олон хүн явдаг байв?

Д: Аан ер нь манай талаас бол их хүн явдаг байсан шүү. Тэгээл ер нь манайх чинь анх нэг боомт нээгдснийг хэлэхүү тэгээл голцуу монголоос л их явдаг. Хятадаас бол орж ирэхгүйдээ тэр улиастай гэдэг хотд наймаа хийдэг байрлаж байдаг аан аймгийг бол тэр чигээрээ хотоос ч их хүмүүс очдог байсан. Бид нар ч гэсэн бас офицер ахлагч нар аан амралтынхаа өдрөөр эд нар бол бас нэг жаахан наймаа хийхгээл анх тэрлүү чинь гардаг л байлаа. Яахав тэгээд янз янзын юм авч гардаг л байсанлдаа яахав тэгээд болж өгвөл бас жаахан юм болгочих санаатай боломжын боломжын юмнууд чирээд очдог. Тэр үед чинь нөгөө хятадууд бас тэр үед жаахан ядуувтар байсан шүүдээ. Ялангуяа тэр улиастайн юу оросын цэргийн цэргийн шинель их авдаг байсан. Тэгээд бид нар чинь яахав оросын цэргийн ангиудаас цэргүүдийн орхиод явсан шинель олж ирдэг байсан. Тийм л байна.

Э: Та хил зөрчсөн хэдэн хүн барьж байсан бэ?

Д: Аан тэр их сонин аан 91 онддоо анх отрядын төвлүү шилжиж ирчихээд тэгээд хилээр явж байхдаа өглөө эрт нэг застав дээр хоночоод дараагийн заставруу явж байсан чинь хятадын талаас нэг хүн манай хилийн бүсийг давчихсан торны цаана явж байсан. Тэгээд тэрнийг хараад жолоочдоо очья гээд жолоочоороо хамгаалуулаад өөрөө бууж очиж баривчилсан. Тэгээд нүд амыг нь боогоод машиндаа хийгээд аваад явсан. Тэгээд хил зөрчигч баривчилсан гэж “онц хилчин” тэмдгээр шагнуулсан. Тэр зураг энэ байна.

Э: Аан та хэдэн хүүхэдтэй вэ? Таны эхнэр таныг цэргийн алба хааж байхад юу хийдэг байв?

Д: Би одоо хүүхэдтэй. 2 эрэгтэй, 2 эмэгтэй. Манай гэр бүлийн хүн бол намагй хилийн заставт байхад нөгөө зочид буудалд хүмүүс нөгөө буудлын хоол хийдэг, хүн байхгүй үед цэргийн хоол хийдэг. Тэгээд ерөөсөө л голцуу цэргийн хоол ундны асуудлыг зохицуулдаг тийм л хүн байсан.

Э: Таны хүүхдүүд одоо юу хийдэг вэ?

Д: Одоо манай хоёр хүүхэд хоёула хилийн цэрэгт алба хааж байгаа. Нэг нь миний алба хааж байсан Сүхбаатарын Эрдэнэцагаанд нэг нь яахав Дорнодод. Аан манай нэг охин хууль зүйн сургууль төгссөндөө бас цэргийн хүнтэй суусан зүүнбаянгийн дивизэд нөхөр нь алба хаадаг. Аан багаохин маань одоо бид хоёртой байгаа.

Э: Аан за та ер нь монголд өрнөсөн энэхүү өөрчлөн байгуулалт, ардчилсан хөдөлгөөнийг хэрхэн юу гэж дүгнэдэг вэ?

Д: Анх зөвлөлтөд яригдаж эхэлсэншдээ. Яригдаж эхэлсэн цагаас нь дэмжиж байсан. Нэг нам носрхцон байлаа шүүдээ. Тэрнийг өөрчлөх нь зөв гэж дэмжиж эхэлсэн даж эхэлсэн цагаас нь дэмжиж байсан. Нэг нам ноёрхцон байлаа шүүдээ. Тэрнийг өөрчлөх нь зөв гэж дэмжиж эхэлсэн. Би энэ зүйлийг баярлаж дэмжиж ыбайдаг хүн. Энэ өөрчлөлт, ардчилсан хөдөлгөөний ачаар өнөөдрийн энэ амьдрал эрх чөлөөтэй байдал бий болж бид нарын амьдрал сайхан боллоо шүүдээ. Би их зөв зүйтэй сайн зүйл болсон гэж үздэг. Гадаад орчин чөлөөтэй болж залуучууд гадагшаа явах ялангуяа хэл сурах гадаад орны соёлтой танилцах гээд маш их хэрэгтэй зүйл болсон гэж боддог.

Э: Зөвлөлт холбоот улс задарсан талаар юу гэж боддог вэ?

Д: Аан ер нь бол зөвлөлт 15 бүгд нараймдах улстай гэдэг байлаашдээ. Монголыг хүртэл 16 дахь бүгд найрамдах улс эд нар гээд л. Ер нь бол ерөөсөө улс орон гэдэг чинь өөрснөө тусгаар тогтноод өөрснөө бие даагаад өөрсдийнхөө ёс заншлаар амьдрах энэ асуудал бол туйлын тэр улс орны зорилго байх ёстой. Нэгэн юманд атгагдаад нэг юм үзэл суртлаар бүх юмыг хийж явуулна гэдэг энэ бол ерөөсөө болохгүй асуудалдаа. Тийм ч учраас зөвлөлт холбоот улс бол өөрсдийнхөө жам ёсоор задарсан гэж боддог. Энэ бол энгэхэл байсан энэ

бол зайлшгүй болох ёстой хэвийн үзэгдэл л гэж ойлгосонлоо. Улс орон тусгаар тогтнож өөрсдийнхөө ёс зан заншлаар байх маш сайхан зүйл болсон.

Э: Амьдралынхаа хамгийн сайхан үеийг аль ше гэж боддог вэ?

Д: Ер нь хүний амьдралд маш сайхан зүйл тохиолддогдоо. Гэхдээ миний хувьд бол 90-ээд оноос хойшхи бол маш сайхан. Нэгдүгээрт бүх зүйл чөлөөтэй болж ирсэн тийн бүх юм өөрчдийнхөө хүний одоо заавраар биш өөрсдийнхөө санаагаар бүх юмыг хийх сурч боловсрох бүх юм нээлттэй үр хүүхдээ сайн сайхан явахыг харах сайхан шүүдээ. Тийм учраас бид нар бол одоо эрх чөлөөтэй хаашаа ч хамаагүй явах ийм явдаг нэгдүгээрт ийм хоёрдугаарт өөрсдийнхөө хэлэх юмыг хэлдэг энэ үе бол одоо бас их аятайхан нэг хүн одоо ухаандаа нэг хүний заалтаар биш дарангуйллаар биш тиймээ чөлөөтэй сэтгэж, чөлөөтэй бодож, чөлөөтэй ажиллаж одоо өөрсдийнхөө хүссэн үр дүнд хүрэх сайхан үелдээ.

Э: Та одоо өөрийнхөө амьдралыг монголчуудын амьдралыг юу гэж төсөөлж байна?

Д: Өөрчлөн байгуулалтыг бол ер нь улсууд бол маш их талархаж хүлээж авсаншдээ. Ер нь одоо хурдан түргэлсэн нэг намын нэг хүчний нэг хүний дарангуйлал доор олон жил оршчихсон хойд урд хоёр хөршөөс өөр юу байхгүй. Харин одоо бол ардчилсан нийгэмд орсноос хойш хүмүүсийн үйл ажиллагаа сайжирсан нь одоо ерөөсөө монголчуудын нэг тодорхой дэвшил бас гадаад оронтой ч харьцсан бүх л юм үйл ажиллагаагаа чөлөөтэй сэтгэж чөлөөтэй явуулж байгаа нь бол маш сайхан тийм ч учраас монголчуудын амьдралд маш сайхан зүйл авчирсан маш сайхан зүйл гэж бодож ойлгож явдаг даа.

Э: Одоо цэргийн хүн намын гишүүн байж болохгүй хэвээрээ юу?

Д: Хэвээрээ хүчний байгууллагын хувьд хэвээрээ. Аан харин миний хувьд тэтгэвэрт гарцан бидний хувьд бол аль намыг дэмжих аль намд орох нь бол чөлөөтэй.

Э: За таньд ярилцлага өгсөнд маш их баярлалаа. Аз жаргал хүсье. Баярлалаа. Баяртай.

Д: За баярлалаа. Та бүхэнд ч бас энэ ажилд тань амжилт хүсье.